ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ

**АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 03 сарын 01 өдөр Дугаар А/09 Улаанбаатар хот

“Олон Улсын Сувилагчдын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2024 оны “Олон Улсын Сувилагчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” А/189 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Олон Улсын Сувилагчдын өдрийг “Бидний сувилагч-Бидний ирээдүй” урианы дор тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2.Олон Улсын Сувилагчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Тэмдэглэлт өдрийн үйл ажиллагаанд шаардагдах зардал болох 1,011,000 (нэг сая арван нэгэн мянга) төгрөгийг урсгал зардлаас тооцож олгохыг Санхүүгийн алба (Б.Мядаг)-нд зөвшөөрсүгэй.

4.Сувилагчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг нийт сувилагчдад танилцуулж, зохион байгуулж ажиллахыг Сувилахуйн алба (Ө.Ариунаа)-нд үүрэг болгосугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэл зүй эрхэлсэн дэд захирал (Б.Батцэцэг)-д даалгасугай.

ЗАХИРАЛ Ц.УРАНЧИМЭГ

9020031090
ХТҮ4419 9104224

D:\АӨСҮТ\А тушаал word\А-19.docx

АӨСҮТ-ийн Захирлын 2024 оны
03 дугаар сарын 01 -ний өдрийн
А/09 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

**“Бидний сувилагч-Бидний ирээдүй” урианы дор Олон Улсын Сувилагчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө**

Зорилго: Сувилахуйн тусламж үйлчилгээний бодлого, чиглэл сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмжийн талаар эрүүл мэндийн байгууллага, сувилагч, мэргэжилтэнд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох.

Зорилт 1: “Эрүүл мэндийн шинэ сэргэлт” нэгдсэн хуралдаан
2.“Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шинэчлэл”
3.“Сувилахуйн хүний нөөц, нийгмийн асуудал
4.“Сувилахуйн удирдлага, манлайллын” чиглэлээр
5.“Нийгмийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж, үйлчилгээний” шинэчлэл
6.Бусад ажлын талаар
Хамрагдах хугацаа: 2024.04.29- 2024.05.30

| № | Зохиох үйл ажиллагаа | Хугацаа | Хариуцах эзэн, хамрагдах байгууллага | Хяналт тавих хүн |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| **1.“Эрүүл мэндийн шинэ сэргэлт” нэгдсэн хуралдаан** | | | | |
| 1.1 | Нэгдсэн хуралд оролцох сувилагч нарын нэрсийг илгээх | 05 дугаар сарын 10 | Сувилахуйн алба | Захиргаа, Сувилахуйн алба |
| 1.2 | Хуралд идэвхтэй оролцоно. | 05 дугаар сарын 13 | Сувилахуйн алба | Оролцогч нар |
| 1.3 | Хуралдаанаас гарсан нэгдсэн дүгнэлт шийдвэрийг сувилагч, мэргэжилтнүүдэд танилцуулах | 05 дугаар сарын 13 | Сувилахуйн алба | Оролцогч нар |
| **2.“Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шинэчлэл”** | | | | |
| 2.1 | Орон нутаг болон дүүргийн сувилагч нар “Арьсны өвчтэй хүнд үзүүлэх сувилахуйн тусламж, хэсэг газрын эмчилгээний онцлог” сэдэвт 2 өдрийн сургалтыг лекц, гардан ажилбараар зохион явуулах | 04 дүгээр сарын 25, 26 | Сувилахуйн алба Ахлах сувилагч нар | Сувилахуйн алба |
| 2.2 | Төрөлжсөн мэргэжлийн лавлагаа төв эмнэлгүүдэд “Ажлын байрны дадлагажуулах сургалтыг зохион явуулах | 04 дүгээр сарын 22, 26 | Сувилахуйн алба Ахлах сувилагч нар | Сувилахуйн алба Завхан аймаг НЭ Дархан уул аймаг НЭ сувилагч нар |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.3 | Эрчимт эмчилгээний 2 сувилагч сувилагч нарт “Тарианы Памп” дээр ажиллах талаар сургалт хийх | 05 дугаар сарын 16 | Сувилагч нар | Эрчимт эмчилгээний ахлах сувилагч |
| 2.4 | Яаралтай тусламжийн үед тоног төхөөрөмж дээр ажиллах ажил мэргэжлийн тэмцээнд бэлтгэн суралцах | 05, 6 дугаар сард | Сувилагч нар | Сувилахуйн алба<br>Эрчимт эмчилгээний сувилагч |
| **3.Сувилахуйн хүний нөөц, нийгмийн асуудал** | | | | |
| 3.1 | Үр бүтээлтэй ажилласан хоёр сувилагчийг шалгаруулж “Цалинтай нэг өдрийн чөлөө” олгож, гэр бүлтэйгээ аз жаргалтай нэг өдрийг өнгөрүүлэх | 05 дугаар сарын 10 | Сувилахуйн албаны<br>Хүний нөөцийн алба<br>Санхүү | Захиргаа |
| 3.2 | Үр бүтээлтэй ажилласан дөрвөн сувилагчийг шалгаруулж “Нэг удаагийн” гоо сайхны үйлчилгээ үзүүлэх | 05 дугаар сарын 10 | Сувилахуйн албаны<br>Хүний нөөцийн алба<br>Санхүү | Захиргаа |
| 3.3 | Үр бүтээлтэй ажилласан хоёр сувилагчийг шалгаруулж “Нөхөн сэргээх” үйлчилгээ үзүүлэх | 05 дугаар сарын 10 | Сувилахуйн албаны<br>Хүний нөөцийн алба<br>Санхүү | Захиргаа |
| 3.4 | “Сувилахуйн чиглэлээр” төгсөх оюутан нарт байгууллагын үйл ажиллагааг танилцуулах, уулзалт ярилцлагыг зохион явуулах | 04 дүгээр сарын 04,18-нд | Сувилахуйн алба<br>Ахлах сувилагч нар | Захиргаа<br>Сувилахуйн алба |
| 3.5 | Тус төвд ажиллах сонирхолтой шинэ залуу сувилагч нартай хамтран ажиллах урилга гардуулан өгөх | 04 дүгээр сарын 04,18-нд | Сувилахуйн алба<br>Ахлах сувилагч нар | Захиргаа<br>Сувилахуйн алба |
| 3.6 | Төвд ажиллах урилга хүлээж авсан сувилагч нараас гэрээ байгуулан ажиллуулна. | 04 дүгээр сарын 04,18-нд | Сувилахуйн алба<br>Ахлах сувилагч нар | Захиргаа<br>Сувилахуйн алба<br>Хүний нөөц |
| 3.7 | “Сувилагч мэргэжлийн ажлын онцлог”, “Сувилагчийн нэг өдрийн” аяныг иргэдийн дунд зохион явуулах. | 05 дугаар сарын 04, 11-нд | Сувилахуйн алба<br>Ахлах сувилагч нар | Захиргаа<br>Сувилахуйн алба<br>Хүний нөөц |
| **4.“Сувилахуйн удирдлага, манлайллын” чиглэлээр** | | | | |
| 4.1 | “Сувилахуйн удирдлага, манлайллын” чиглэлийн сургалтад шинэ ахлах сувилагч нараас хамруулна. | 05 дугаар сард | Шинэ ахлах сувилагч нар | Захиргаа<br>Чанарын алба<br>Сувилахуйн алба |
| **5.Нийгмийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж, үйлчилгээний” шинэчлэл** | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5.1 | АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн “Багш шавийн эрдмийн уулзалтыг” 2024 зохион явуулах, “Сувилагчаа алдаршуулъя” сэдэвт өдөрлөг хийх | 05 дугаар сарын 23 | Уулзалтад оролцох багш, Тасаг, нэгжийн ахлах болон сувилагч нар Олон жил ажилласан сувилагч нар | Захиргаа Сургалтын алба Сувилахуйн алба АШУҮСургуулийн сувилагчийн сургуулийн |
| 5.2 | Сувилагч, мэргэжилтнүүдэд АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулиас “Сувилахуйн судалгаа” сэдэвт сургалт авах | 05 дугаар сарын 23 | Сургалт явуулах багш Сувилагч, мэргэжилтнүүд | Сувилахуйн алба |
| 5.3 | Сувилахуйн албанаас гаргасан хуваарийн дагуу иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгохыг төвийн цахим вэб хуудсанд “Подкастыг” сувилагч, мэргэжилтнүүд хийх. | 04, 05 дугаар саруудад | Ахлах сувилагч Сургалт явуулах сувилагч | Сургалтын алба Сувилахуйн алба |
| | **6.Бусад ажлын талаар** | | | |
| 6.1 | Төрийн болон нийслэлийн шагналд сувилагч нарын материалыг хүргэх | 04, 05 дугаар сард | Сувилагч нар | Хүний нөөцийн менежер Тухайн сувилагч |
| 6.2 | Товч тайланг ЭМЯ-нд хүргэх | 05 дугаар сард | Ахлах сувилагч | Сувилахуйн алба |

АӨСҮТ-ийн Захирлын 2024 оны
.03 дугаар сарын 01. -ний өдрийн
А/09 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

**“Бидний сувилагч-Бидний ирээдүй” урианы дор Олон Улсын Сувилагчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны зардлын төсөв**

| № | Зохиогдох үйл ажиллагаа | Хугацаа | Зарцуулагдах мөнгө | Нийт зардал |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Орон нутаг болон дүүргийн сувилагч нар “Арьсны өвчтэй хүнд үзүүлэх сувилахуйн тусламж, хэсэг газрын эмчилгээний онцлог” сэдэвт 2 өдрийн сургалтыг лекц, гардан ажилбараар зохион явуулах | 04 дүгээр сарын 25, 26 | | |
| 2 | Төрөлжсөн мэргэжлийн лавлагаа төв эмнэлгүүдэд “Ажлын байрны дадлагажуулах сургалтыг зохион явуулах | 04 дүгээр сарын 22, 26 | | |
| 3 | Үр бүтээлтэй ажилласан хоёр сувилагчийг шалгаруулж “Цалинтай нэг өдрийн чөлөө” олгож, гэр бүлтэйгээ аз жаргалтай нэг өдрийг өнгөрүүлэх | 05 дугаар сард | 60,500*2 | 121,000 |
| 4 | Үр бүтээлтэй ажилласан дөрвөн сувилагчийг шалгаруулж “Нэг удаагийн” гоо сайхны үйлчилгээ үзүүлэх | 05 дугаар сард | Гүн тэжээл өгөх аппарат 45,000*2<br>Усан массажны аппарат 45,000*2 | 90,000<br>90,000 |
| 5 | Үр бүтээлтэй ажилласан хоёр сувилагчийг шалгаруулж “Нөхөн сэргээх” үйлчилгээ үзүүлэх | 05 дугаар сард | Тенс аппаратад орох 10,000*3=30,000х2 | 60,000 |
| 6 | “Сувилахуйн чиглэлээр” төгсөх оюутан нарт байгууллагын үйл ажиллагааг танилцуулах, уулзалт ярилцлагыг зохион явуулах | 04 дүгээр сарын 04, 18 | | |
| 7 | Сувилагч мэргэжлийн ажлын онцлог”, “Сувилагчийн нэг өдрийн” аяныг иргэдийн дунд зохион явуулах | 05 дугаар сарын 04, 11 | | |
| 8 | Сувилахуйн удирдлага, манлайллын” чиглэлийн | 05 дугаар сард | 150,000 | 150,000 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | сургалтад шинэ ахлах сувилагч нараас хамруулна. | | | |
| 9 | АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн "Багш шавийн эрдмийн уулзалтыг" 2024 зохион явуулах, "Сувилагчаа алдаршуулъя" сэдэвт өдөрлөг хийх | 5 дугаар сарын 23 | 500,000 | 500,000 |
| **Нийт дүн** | | | | **1,011,000** |